



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 08
№18 (1266)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

241.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 24	1235
242.	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай	Дугаар 27	1236
243.	Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай	Дугаар 28	1239

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

244.	Журам батлах тухай	Дугаар 465	1242
245.	Журам батлах тухай	Дугаар 466	1245



᠘᠔᠘. ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	᠒᠕᠔᠕
᠘᠔᠗. ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	᠒᠕᠔ᠶ
᠘᠔᠘. ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	᠒᠕᠔ᠷ
᠘᠔᠙. ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	᠒᠕᠔ᠸ
᠘᠅᠐. ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	ᠮᠠᠮᠤ ᠪᠠᠭᠠᠨ ᠠᠨᠢ	᠒᠕᠔ᠹ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14^{1.2}, 14^{1.3} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг доор дурдсанаар баталсугай:

Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр:

- 1/Сангийн сайд
- 2/Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
- 3/Эрүүл мэндийн сайд

Даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр:

- 1/Б.Алтанхуяг -Монголын төмөр замчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны дэд дарга
- 2/Т.Баясгалан -Шинжлэх Ухааны Академийн харьяа Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
- 3/С.Эрдэнэбат -Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны ерөнхийлөгч

Ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр:

- 1/Ж.Гэрэлмаа -Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн
- 2/Ш.Зоригоо -Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооны ерөнхийлөгч
- 3/Н.Одонгуа -Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн гишүүн

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

<p>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᣳᠠᠨ ᠶ᠋ᣳᠠᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ</p>	<p>ᠭᠡᠨ ᠭᠡᠨ</p>	<p>ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᣳᠠᠨ ᠶ᠋ᣳᠠᠨ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠳᠠᠷᠭ᠋᠎ᠠ</p>
<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>
<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>
<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>
<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>
<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>
<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>	<p>ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ ᠲᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠤᠰᠦᠭᠡᠢ</p>

Индрига Фолд на Укна Норда на Довдига



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Засгийн газарт эрх олгох тухай хуулийн 3 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1, 93.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улс орны эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, гадаад валютын орох урсгал, нөөцийг нэмэгдүүлэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасугай.

2. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/онцгой дэглэм тогтоосон 6 сарын хугацаанд багтаан компанийн удирдлага, зохион байгуулалтын оновчтой бүтцийг бий болгож, засаглалыг сайжруулж, гүйцэтгэх удирдлагыг ил тод, нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох;

2/компанийн үйл ажиллагаанд олон улсын нэр хүндтэй, хөндлөнгийн аудитын компаниар нэн даруй аудит хийлгэх;

3/“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үндсэн үйл ажиллагаанд эрх зүйн нийтлэг хэм хэмжээ, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг чанд сахин мөрдүүлж, олон улсын болон Монгол Улсын стандарт, шаардлагыг хангуулах;

4/онцгой дэглэм тогтоосон хугацаанд холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, цаашид хэвийн, тогтвортой ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

5/Монгол Улсын Их Хурлын 2023 оны 08 дугаар тогтоолын 1 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах талаар шуурхай арга хэмжээ авч, тус тогтоолын биелэлтийн явцыг сар бүр Улсын Их Хуралд танилцуулах.



3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо /Т.Энхтүвшин/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ-ᠤᠨ ᠡᠳᠢᠶ᠋ᠢᠨ ᠵᠢᠰᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ

ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

ᠮᠤᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠴ.ᠴᠡᠷᠢᠨᠫᠤᠮᠤᠨᠴᠢᠭ/,
ᠶᠡᠶᠢᠯᠳᠦᠪᠦᠷᠵᠢᠯᠲᠢᠶᠢᠨ ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠨᠭᠢᠨ ᠬᠣᠷ᠎ᠠ /ᠲ.ᠡᠨᠬᠡᠲᠦᠪᠰᠢᠨ/-ᠨᠳᠤ ᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠪᠣᠯᠭᠣᠰᠤᠭᠠᠢ.

**Монгол Улсын
Их Хурлын Дарга**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 465

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 15.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Улсын өмгөөлөгчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Улсын өмгөөлөгчийн мөнгөн урамшуулалд шаардагдах зардлын эх үүсвэрийг хуулиар тогтоосон хугацаатай нь уялдуулан улсын төсвийн төсөлд тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

Засгийн газрын 2022 оны 465 дугаар
тогтоолын хавсралт

УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧИД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 19.1.3-т заасны дагуу улсын өмгөөлөгчид таван жил тутамд мөнгөн урамшуулал олгоход энэ журмыг баримтална.

1.2.Улсын өмгөөлөгчийн Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 19.1.3-т заасан ажилласан жилийг тооцохдоо Хууль зүйн туслалцааны тухай хуулийн (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тоолно.

Хоёр.Мөнгөн урамшуулал олгоход тавигдах шаардлага

2.1.Улсын өмгөөлөгчийн тасралтгүй таван жил ажилласан хугацааг тоолохдоо түүнийг ажилд томилсон тушаал, шаардлагатай бол нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, архивын лавлагаа зэрэг баримтыг үндэслэнэ.

2.2.Энэ журмын 2.1-д заасан ажилласан хугацааг тоолохдоо дараах хугацааг хамааруулж тооцно:

2.2.1.ажлаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхийн шийдвэрээр эргүүлэн тогтоосон бол уг шалтгаанаар ажилгүй байсан хугацаа;

2.2.2.баривчлагдсан буюу цагдан хоригдсон этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан, шүүхээс цагаатгах тогтоол гаргасан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон хугацаа;

2.2.3.гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтын бүсэд дайчлагдан ажилласан хугацаа.

2.3.Энэ журмын 2.1-д заасан хугацааг тоолохдоо улсын өмгөөлөгчийн аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил, аймгийн төв, алслагдсан дүүрэгт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа хугацааг оруулан тооцно.

Гурав.Мөнгөн урамшуулал олгох

3.1.Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 19.1.3-т заасан шаардлагыг хангасан улсын өмгөөлөгч мөнгөн урамшуулал авах хүсэлтээ Хууль зүйн туслалцааны төвийн төсвийн шууд захирагчид бичгээр гаргана.

3.2.Энэ журмын 3.1-д заасан хүсэлтийг Хууль зүйн туслалцааны төвийн хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хүлээн авч, холбогдох баримт бичиг, ажилласан хугацааг тодорхойлон мөнгөн урамшуулал олгох шийдвэр гаргуулах саналыг байгууллагын захиралд уламжлан шийдвэрлүүлнэ.

3.3.Хууль, энэ журамд заасан шаардлага хангасан улсын өмгөөлөгчид байгууллагын захирлын тушаалаар мөнгөн урамшууллыг олгоно.

Дөрөв.Бусад

4.1.Хууль зүйн туслалцааны төв нь мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгуулан хэрэгжүүлнэ.

4.2.Улсын өмгөөлөгчид мөнгөн урамшуулал давтан олгох хугацааг мөнгөн урамшуулал авах эрх үүссэн өдрөөс эхлэн тоолно. Хугацааг тоолохдоо Иргэний хуулийн Наймдугаар бүлэгт заасан хугацаа тодорхойлох, тоолох журмыг баримтална.

4.3.Улсын өмгөөлөгчийн үндсэн цалин болон ажилласан хугацааг албаны бүрэн эрхээ хэтрүүлэн ашиглаж буруу тодорхойлох, хуурамч баримт бичиг бүрдүүлэх зэргээр мөнгөн урамшууллыг хууль бусаар тогтоож олгосон албан тушаалтан, түүнийг хууль бусаар бүрдүүлэхэд оролцсон өмгөөлөгч, эрх бүхий албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 466

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 5, 11 дүгээр зүйлийн 2-т заасныг тус тус үндэслэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан цахим арилжаанд хяналт тавих журмыг хамтран баталж, мөрдүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт үүрэг болгож, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д зөвлөсүгэй.

3.Энэ тогтоолын 1-д заасан журмын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК (С.Наранцогт), “Эрдэнэс Тавантолгой” ХК (Ж.Ганбат), “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК (Х.Алтай)-д тус тус үүрэг болгосугай.

4.Цахим арилжаагаар экспортод гаргах нүүрсний ачаа тээвэрлэлтийг Гашуунсухайт боомт дахь чингэлэгт тээврийн терминалаар тусгай горимоор зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Монгол Улсын сайд, Боомт сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн) нарт тус тус даалгасугай.

5.Энэ тогтоолыг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ж.ГАНБААТАР

Засгийн газрын 2022 оны 466 дугаар
тогтоолын хавсралт

ЭКСПОРТОД ГАРГАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ЦАХИМ АРИЛЖААНЫ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэ журмаар “Эрдэнэс Тавантолгой” ХК болон хүсэлт гаргасан Гашуунсухайт боомт дахь “Чингэлэгт тээврийн терминал”-аар нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийн экспортод гаргах нүүрсийг цахимаар нээлттэй арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулна.

1.2.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1.“цахим арилжаа” гэж экспортод гаргах нүүрсийг худалдагчаас санал болгосон доод үнээс эхлэн цахимаар үнэ хаялцуулан нээлттэй арилжих үйл ажиллагааг;

1.2.2.“худалдагч” гэж “Эрдэнэс Тавантолгой” ХК болон хүсэлт гаргасан Гашуунсухайт боомт дахь “Чингэлэгт тээврийн терминал”-аар нүүрс экспортлогч аж ахуйн нэгжийг;

1.2.3.“худалдан авах санал гаргагч” гэж нүүрс худалдан авахаар цахим арилжаанд оролцогч этгээдийг;

1.2.4.“худалдан авагч” гэж цахим арилжаагаар нүүрс худалдан авахаар шалгарч, худалдагчтай экспортын гэрээ байгуулсан этгээдийг;

1.2.5.“арилжаа зохион байгуулагч” гэж цахим системээр дамжуулан арилжаа зохион байгуулах хуулийн этгээд буюу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийг;

1.2.6.“дэнчин” гэж худалдан авах санал гаргагчаас цахим арилжааны үүргийн гүйцэтгэлийн нотолгоо болгож худалдагчид төлбөл зохих төлбөрт оролцуулан арилжаа зохион байгуулагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкны нэрийн дансанд урьдчилан байршуулах мөнгөн хөрөнгийг;

1.2.7.“нүүрс нийлүүлэх цэг” гэж Монгол Улсын Гашуунсухайт боомт дахь “Чингэлэгт тээврийн терминал”-ыг;



1.2.8.“итгэмжлэгдсэн лаборатори” гэж Гаалийн төв лаборатори, эсхүл Монгол Улсын итгэмжлэгдсэн лабораторийг;

1.2.9.“экспортын гэрээ” гэж цахим арилжааны системд амжилттай хийгдсэн хэлцлийн дагуу “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аас баталсан загвараар байгуулах нүүрс экспортлох худалдааны гэрээг.

Хоёр.Цахимаар оролцох экспортын нүүрсэнд тавигдах шаардлага, хэмжээ

2.1.Арилжаа зохион байгуулагч нь “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2022” стандартад заасан төрөл, ангилал, чанарын үзүүлэлттэй нүүрсийг цахимаар арилжина.

2.2.Цахимаар арилжих нүүрсний нэг багц нь 6,400 тонн бөгөөд нэг удаагийн захиалгын дээд хэмжээ нь 25 хүртэл багц байна.

2.3.Худалдагч нь цахимаар арилжих нүүрсний захиалгыг дараах баримт бичгийн бүрдүүлбэрийг ханган арилжаа зохион байгуулагчид тухай бүр өгнө:

2.3.1.цахимаар арилжаалах нүүрсний багцын тоо, тухайн багцад хамаарах нүүрсний төрөл, ангилал, чанарын үзүүлэлт;

2.3.2.итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт (цахим);

2.3.3.дуудах доод үнэ, валютын төрөл.

2.4.Арилжаа зохион байгуулагч нь худалдагчаас ирүүлсэн тоо хэмжээг хэтрүүлэхгүйгээр захиалгад заасан хэмжээгээр цахим арилжааг зохион байгуулна.

2.5.Захиалгын бүрдүүлбэр хангаагүй захиалгыг бүртгэхгүй.

Гурав.Цахим арилжааг зохион байгуулах

3.1.Арилжаа зохион байгуулагч нь цахим арилжааг нээлттэй, ил тод, оролцогчдын тэгш эрхийг хангасан байдлаар зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтоох, арилжаалагдаж буй нүүрсний үнэ, гэрээний мэдээллийг арилжаанд оролцогчид болон олон нийтэд үнэн зөв, түргэн шуурхай хүргэх, арилжааны хэлцлийн үр дүнд үүссэн төлбөрийн үүргийг тодорхойлон бүртгэх, экспортын гэрээ байгуулах, төлбөрийг найдвартай гүйцэтгэх нөхцөлийг хангаж ажиллана.

3.2.Худалдагч нь худалдах нүүрсний захиалгыг арилжаа зохион байгуулагчид арилжаа зохион байгуулагдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө өгнө.

3.3.Арилжаа зохион байгуулагч нь энэ журмын 3.2-т заасан захиалгын бүрдүүлбэрийг ажлын 2 өдрийн дотор шалгаж, шаардлага хангасан гэж үзвэл захиалгын дагуу цахим арилжааны зарыг арилжаа зохион байгуулагдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө өөрийн албан ёсны цахим хуудаст байршуулна.

3.4.Цахим арилжааны зард дараах мэдээллийг тусгана:

3.4.1.цахим арилжаа зохион байгуулах хугацаа;

3.4.2.нүүрсний багцын тоо, чанар, стандарт;

3.4.3.нүүрс нийлүүлэх цэг (Гашуунсухайт боомт дахь Чингэлэгт тээврийн терминал);

3.4.4.нүүрс хүргэж өгөх хугацаа;

3.4.5.нүүрс татан авах хугацаа;

3.4.6.дуудах доод үнэ, валютын төрөл;

3.4.7.дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн;

3.4.8.дэнчингийн хэмжээ, төлөх нөхцөл, дэнчин байршуулах дансны дугаар, валютын төрөл;

3.4.9.цахим арилжаанд оролцох заавар;

3.4.10.мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар.

3.5.Худалдан авах санал гаргагч нь арилжаа эхлэхээс 30-аас доошгүй минутын өмнө Арилжаа зохион байгуулагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд дахь дансанд дэнчинг байршуулснаар цахим арилжаанд оролцох эрх үүснэ.

3.6.Цахим арилжааны системд хэлцэл амжилттай хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор худалдагч болон худалдан авагч нар арилжаа зохион байгуулагчаас баталсан загварын дагуу экспортын гэрээг баталгаажуулан арилжаа зохион байгуулагчид ирүүлэх бөгөөд худалдан авагч нь хэлцлийн төлбөрийг 100% (дэнчинг хассан дүнгээр) худалдагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банканд дахь нэрийн дансанд



байршуулна. Арилжаа зохион байгуулагч нь экспортын гэрээнд үндэслэн дэнчинг худалдагчийн нэрийн данс руу ажлын 5 өдрийн дотор шилжүүлнэ.

3.7.Цахим арилжаанд оролцох дэнчингийн хэмжээ нь доод үнээр илэрхийлсэн тухайн захиалгын нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцүү хэмжээтэй байна.

3.8.Цахим арилжааны арга, ашиглах нөхцөлийг дараах байдлаар тогтооно:

3.8.1.нүүрсний багцын дуудах доод үнийг худалдагч тал захиалгад тусгасан байна;

3.8.2.цахим арилжааны үед хэлцэл хийгдэх хүртэл үлдэж байгаа хугацааг секундээр тооцон арилжаанд оролцогчид харуулна;

3.8.3.цахим арилжаа нь захиалга бүртгэх, дуудах, хэлцэл хийгдэх гэсэн 3 үе шаттайгаар явагдана;

3.8.4.худалдан авах анхны захиалга бүртгэх үе шат нь 60 минут хүртэл хугацаанд үргэлжлэх бөгөөд энэ үед захиалгыг өөрчлөх, эсхүл цуцалж болно;

3.8.5.дуудах үе шат нь 1 минутын хугацаанд үргэлжилнэ. Дуудах үед шинээр захиалга оруулах, тоо ширхгийг өөрчлөх болон үнийг бууруулан захиалгад өөрчлөлт оруулахыг хориглох бөгөөд зөвхөн арилжааны системд бүртгэгдсэн захиалга дуудах үед оролцон үнэ хаялцах эрхтэй;

3.8.6.дуудах үе шатанд үнэ шинэчлэгдсэн тохиолдол бүрд энэ зүйлийн 3.8.5-д заасан 1 минутын дуудах үе шатны хугацаа эхлэн тооцогдоно;

3.8.7.сүүлийн үнийн өөрчлөлт орсноос хойш 1 минутын хугацаанд дахин өөрчлөлт ороогүй тохиолдолд хэлцэл хийгдсэнд тооцно.

3.9.Арилжаа зохион байгуулагч нь нүүрсний цахим арилжааны мэдээ, тайланг өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлнэ.

3.10.Биржийн арилжааны шимтгэл нь арилжааны үнийн дүнгийн 0.1 %-тай тэнцүү байна.

3.11.Арилжаа зохион байгуулагч нь цахим арилжааны системтэй холбоотой сургалтыг шаардлагатай тохиолдолд өөрийн санаачилгаар болон сонирхогч этгээдийн хүсэлтээр зохион байгуулж болно.



Дөрөв.Төлбөр тооцоо

4.1.Худалдан авагч нь энэ журмын 3.6-д заасны дагуу байгуулсан экспортын гэрээнд үндэслэн хэлцлийн төлбөрийг ажлын 7 өдрийн дотор худалдагчийн Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкн дахь нэрийн дансанд байршуулна.

4.2.Арилжаа зохион байгуулагч нь дэнчинг энэ журмыг зөрчиж аливаа этгээдэд шилжүүлэх, барьцаалахыг хориглоно.

4.3.Арилжаа явагдаагүй тохиолдолд тухайн арилжааг товлосон өдрөөс хойш, арилжаанд оролцоогүй, эсхүл оролцсон боловч шалгараагүй тохиолдолд арилжаа явагдсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор арилжаа зохион байгуулагч нь худалдан авах санал гаргагчид дэнчинг буцаан олгох бөгөөд банкны гүйлгээний шимтгэлийг арилжаа зохион байгуулагч хариуцахгүй.

4.4.Энэ журмын дагуу арилжаа зохион байгуулагчийн цахим арилжаагаар Монгол Улсын Гашуунсухайт боомт дахь “Чингэлэгт тээврийн терминал” нөхцөлөөр худалдан борлуулсан нүүрсэнд татвар, төлбөр, хураамжийг экспортод гаргасан нүүрсний зохицуулалтын дагуу ногдуулна.

4.5.Цахим арилжаагаар нүүрс худалдан авахаар шалгарсан этгээд нь хэлцэл амжилттай хийгдсэн боловч хэлцлийн төлбөрийг хугацаандаа, эсхүл бүрэн шилжүүлээгүй, журмын 3.6-д заасны дагуу экспортын гэрээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр байгуулахаас татгалзсан, энэ журмыг зөрчиж арилжаанд оролцсон тохиолдолд худалдагчийн хүсэлтээр арилжаа зохион байгуулагч нь тухайн хэлцлийг цуцалж, дэнчинг худалдагчийн орлого болгоно.

4.6.Энэ журмын 4.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд худалдагч нь тухайн цуцлагдсан хэлцлийн захиалгаа арилжаа зохион байгуулагчид шинэчлэн хүргүүлнэ.

4.7.Цахим арилжаагаар нүүрс худалдан авахаар шалгарсан этгээдийн хэлцлийн төлбөрийн үнийн дүнд дэнчинг оруулан тооцно.

Тав.Худалдагч

5.1.Худалдагч нь энэ журмын 3.4-т заасан цахим арилжааны захиалгыг арилжаа зохион байгуулагчид урьдчилан хүргүүлнэ.

5.2.Шаардлагатай тохиолдолд арилжаа зохион байгуулагч эсхүл арилжаанд оролцогчийн шаардлагаар арилжаалах нүүрсний талаар нэмэлт мэдээлэл өгч болно.

5.3.Худалдагч нь төлбөр тооцоонд цахим төлбөрийн баримт үйлдэж, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд хэлцлийг бүртгэнэ.

Зургаа.Худалдан авах санал гаргагч

6.1.Гадаад болон дотоодын хуулийн этгээд нь цахим системд бүртгүүлж худалдан авах санал гаргагчаар арилжаанд оролцоно.

6.2.Худалдан авах санал гаргагч нь энэ журмын 6.1-д заасан цахим системд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна:

6.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

6.2.2.оршин суугаа улсын татвар төлөгчийн гэрчилгээ, татвар төлөгчийн дугаар;

6.2.3.харилцагч банкны дансны тодорхойлолт;

6.2.4.гадаад хэл дээрх баримт бичгийг англи хэл дээрх албан ёсны орчуулгын хамт.

6.3.Худалдан авах санал гаргагч нь бусад этгээдтэй үгсэн хуйвалдах, харилцан тохиролцох замаар цахим системээр арилжигдах нүүрсний үнийг зохиомлоор тогтоох, зах зээлийг урвуулан ашиглах зорилгоор аливаа үйлдэл хийхийг хориглоно.

6.4.Худалдан авах санал гаргагч нь энэ журмын 6.3-т заасан үйлдэл хийсэн тохиолдолд арилжаа зохион байгуулагч цахим системд 6-12 сарын хугацаанд дахин бүртгэхгүй байх арга хэмжээ авна.

Долоо.Итгэмжлэгдсэн лаборатори

7.1.Цахимаар арилжаалах нүүрсний чанарын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийнэ.

7.2.Итгэмжлэгдсэн лаборатори нь хараат бусаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу ажиллана.

7.3.Арилжаа зохион байгуулагч нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээг хүлээн авснаар цахим арилжааг зохион байгуулна.

7.4.Худалдагч, худалдан авагч талууд экспортын гэрээнд заасны дагуу шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж болно.

Найм.Тээвэрлэлт

8.1.Гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгийг худалдагч тал хариуцна.

8.2.Худалдагч нь нүүрс нийлүүлэх цэг хүртэлх тээвэрлэлт, тээвэрлэлттэй холбоотой эрсдэлийг хариуцна.

8.3.Нүүрс нийлүүлэх цэгээс цааш гарах тээвэрлэлтийг худалдан авагч хариуцна.

Ес.Бусад

9.1.Энэ журмын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

9.2.Худалдагчийн хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаас бусад түүний буруутай үйл ажиллагааны улмаас экспортын гэрээнд заасан хугацаанд зохих нүүрсийг нийлүүлэх цэгт бүрэн хүргээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлэх цэгт хүргээгүй нүүрсний үнийн дүнгийн 0.1 %-тай тэнцэх алдангийг худалдан авагчид төлнө.

9.3.Худалдан авагч нь экспортын гэрээнд заасан хугацаанд худалдан авсан нүүрсээ нүүрс нийлүүлэх цэгээс бүрэн татан аваагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд татан аваагүй нүүрсний үнийн дүнгийн 0.1 %-тай тэнцэх хэмжээний алдангийг худалдагчид төлнө.

9.4.Цахим арилжаа зохион байгуулахтай холбоотой нарийвчилсан харилцааг энэ журмын 1.2.5-д заасан этгээдийн баталсан журам, заавраар зохицуулна.

9.5.Худалдагч, худалдан авагч нарын хооронд үүсэх маргааныг талууд өөрөөр тохиролцоогүй бол Монгол Улсын Олон улсын арбитраар шийдвэрлүүлж болно.

---o0o---

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.25

Индекс: 200003